



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/6121

Булган сум

Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдэд
сургалт зохион байгуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн аврах бүлэг цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн нэгдсэн сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 16-аас 09 дүгээр сарын 26-ний хооронд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд төвлөрүүлэн зохион байгуулсугай.


2. Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй сургалт зохион байгуулах бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, зарцуулах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Сургалтад шаардагдах 5,641,000 (таван сая зургаан зуун дөчин нэгэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

4. Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй явуулах сургалтыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 2024 оны 10 дугаар сарын 05-ны дотор илтгэхийг Цэргийн штаб (Хурандаа Ч.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010837


Аймгийн Засаг даргын 20.24.09-ны
09 дүгээр сарын 09-ны ний өдрийн А.16.19 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ СУРГАЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Сургалтын удирдагч	Хур Ч.Энхбаяр	- ЦШ-ын дарга
Сургалтын төвийн захирал	х/ч Б.Намнансүрэн	- ЦШ-ын ОНХС-ын офицер
Багш нар	х/ч Ц.Цэрэнтогтох	- ЦШ-ын Дайчилгааны офицер
	х/ч Г.Эрдэнэхүү	- 186-р ангийн офицер
	д/ч Э.Мөнх-Эрдэнэ	- Онцгой байдлын газар
Жагсаалын дарга	а/ч Н.Болдбаатар	- ЗХ-ний 186-р анги
Тогооч	Д. Батжаргал	- ЗХ-ний 186-р анги

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 09-ны нийгмийн А/614 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



СУРГАЛТАНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Тайлбар
1	2	3	4
1	Хоолны үнэ	3,600,000	Цэргийн албан хаагчийн хоногийн хоолны нормоор 18000 төг*20хүн *10 хоног
2	Багш нар, тогоочийн цалин	1,000,000	5 хүн*20000 төг*10 хоног
3	Бичиг хэргийн зардал	95,000	Дэвтэр, бал 1хүн 3500 төг Бичгийн цаас 1ш 25.000
4	Шатахуун	696,000	200л Түлш 3480
5	Бусад	250,000	Шүдний 00, саван ,00 цаас
Бүгд			5,641,000